



**ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖ  
ТӨРИЙН ӨМЧИТ ХЯЗГААРЛАГДМАЛ  
ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2022 оны 04 сарын 07 өдөр

Дугаар А/39

Улаанбаатар хот

**Журам шинэчлэн батлах тухай**

Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийн 10, 11 дүгээр зүйл, Компанийн дүрмийн 14 дүгээр зүйлийн 14.4.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн “Гишүүнчлэлийн журам”-ыг хавсралтаар шинэчлэн баталсугай.
2. Шинэчлэгдэн батлагдсан журмыг биржийн ажилтан, харилцагчдад танилцуулж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг хэлтсийн менежер нарт үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаал гарсан холбогдуулан Гүйцэтгэх захирлын 2016 оны 4 дүгээр сарын 06-ны өдрийн А/15 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.
4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дэд захирал /Р.Ариунбат/-д үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



О.НАРАНДЭЛГЭР

Гүйцэтгэх захирлын 2022 оны  
...04... дүгээр сарын ...07-ны  
өдрийн 117 дугаар тушаалын  
нэгдүгээр хавсралт



## ГИШҮҮНЧЛЭЛИЙН ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү “Гишүүнчлэлийн журам”-ын /цаашид “Журам” гэх/ зорилго нь “Хөдөө аж ахуйн бирж” ХХК /цаашид “Бирж” гэх/ нь “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай” хууль /цаашид “Биржийн тухай хууль” гэх/-д заасны дагуу биржийн арилжаанд оролцогч байнгын болон байнгын бус гишүүнд тавигдах шаардлага, биржид гишүүнээр элсүүлэх, эрхийг түдгэлзүүлэх, цуцлах, сургах, үйл ажиллагаанд хяналт тавихтай холбоотой харилцааг тодорхойлж, зохицуулахад оршино.

1.2. Зохицуулалтыг биржийн тухай хууль, Иргэний хууль, Биржийн үйл ажиллагааны ерөнхий журам болон тэдгээрт нийцүүлэн гаргасан бусад дүрэм, журам, эрх зүйн баримт бичгийн хүрээнд хэрэгжүүлнэ.

1.3. Журмаар зохицуулаагүй харилцааг Санхүүгийн зохицуулах хорооны холбогдох журмаар зохицуулна.

### Хоёр. Биржийн үйл ажиллагаа

2.1 Бирж нь байнгын болон байнгын бус гишүүнд тавигдах шалгуур үзүүлэлтийг баталж, мөрдүүлнэ.

2.2 Биржийн ТУЗ нь байнгын бус гишүүний суудлын, байнгын гишүүний элсэлтийн болон жилийн хураамжийн хэмжээг тогтооно.

2.3 Бирж нь гишүүнээр элсэх хүсэлт гаргахад шаардлагатай бичиг баримтын бүрдүүлбэрийг хангуулах, шаардлага хангасан этгээдэд гишүүний эрх олгож, Гишүүнчлэлийн гэрээ байгуулах, гэрээг сунгах, холбогдох дүрэм, журмыг зөрчсөн тохиолдолд эрхийг түдгэлзүүлэх, цуцлах хүртэл арга хэмжээг авна.

2.4 Биржийн тухай хууль, Биржийн үйл ажиллагааны ерөнхий журамд заасны дагуу биржийн арилжаанд оролцогч байнгын болон байнгын бус гишүүнийг сургах, мэргэшүүлэх ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулна.

2.5 Бирж нь Гишүүнчлэлийн гэрээг 1 жилийн хугацаагаар байгуулна. Гэрээний загварыг энэхүү журмын хавсралтаар батална. /Хавсралт 2,3/

2.6 Биржийн гишүүний үйл ажиллагаанд хяналт тавих, гэрээний үүргийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт, шалгалт зохион байгуулна.

2.7 Гишүүнчлэлийн гэрээний хэрэгжилтийг жил тутам дүгнэх бөгөөд Бирж болон гишүүний хооронд маргаан гарсан тохиолдолд Хяналтын журмаар зохицуулна.

2.8 Биржийн гишүүнтэй байгуулсан Гишүүнчлэлийн гэрээ, холбогдох бусад материалыг Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд заасны дагуу архивын нэгж болгон хадгална.

## **Гурав. Гишүүнчлэлийн төрөл, гишүүний үйл ажиллагаа**

- 3.1 Биржийн арилжаанд оролцогчийг байнгын болон байнгын бус гишүүн гэж ангилна
- 3.2 Биржийн гишүүн нь Санхүүгийн зохицуулах хорооны гишүүний үйл ажиллагааг зохицуулсан журам, Биржийн холбогдох журмууд болон Гишүүнчлэлийн гэрээг дагаж мөрдөнө.
- 3.3 Биржийн гишүүн нь энэхүү журам болон Гишүүнчлэлийн гэрээгээр олгосон эрхийн хүрээнд Биржээс зөвшөөрсөн үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотой шимтгэл, хураамжийг нэхэмжилсэн хугацаанд төлнө.
- 3.4 Шимтгэл, хураамж төлсөн баримтыг гишүүнчлэл хариуцсан хэлтэст ирүүлнэ.
- 3.5 Биржийн гишүүнээр элсэх хүсэлт гаргах, бүрдүүлэх материалыг Биржид ирүүлэх, Гишүүнчлэлийн гэрээг сунгах хүсэлтийг гэрээ дуусгавар болохоос ажлын 5 өдрийн өмнө гишүүнчлэл хариуцсан хэлтэст холбогдох баримт бичгийн хамт ирүүлсэн байна.
- 3.6 Биржээс гишүүнд зориулан зохион байгуулж буй аливаа арга хэмжээ, сургалтад хамрагдаж, чадавхаа дээшлүүлж, хөгжүүлэлтийг хэрэгжүүлж ажиллана.
- 3.7 Байнгын гишүүн нь Биржийн тухай хуулийн 10.4-т заасан шаардлагыг хангаж, Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл авсан, үндэсний хөрөнгө оруулалт давамгайлсан хуулийн этгээд байна.
- 3.8 Байнгын гишүүн нь дараах эрхүүдийг бүхэлд нь болон хэсэгчлэн эдэлнэ. Үүнд.
- 3.8.1 Гишүүнчлэлийн;
  - 3.8.2 Арилжааны;
  - 3.8.3 Клирингийн;
  - 3.8.4 Зах зээл үүсгэх;
- 3.9 **Гишүүнчлэлийн эрх:** Энэ нь харилцагчийн бүртгэл хөтлөх эрхийг ойлгох бөгөөд Биржтэй байгуулсан гишүүнчлэлийн гэрээний хүчинтэй хугацаанд гишүүнчлэлийн эрхийг эдэлнэ.
- 3.10 Гишүүнчлэлийн эрхтэй байнгын гишүүн нь дараах үйл ажиллагааг эрхэлнэ. Үүнд:
- 3.10.1 Харилцагчтай зуучлалын гэрээ байгуулж, харилцагчид арилжааны данс нээнэ.
  - 3.10.2 Данс нээхтэй холбоотой харилцагчийн мэдээллийг Биржийн програмд үнэн зөв бүртгэнэ.
- 3.11 **Арилжааны эрх:** Биржийн арилжаанд өөрийн болон харилцагчийн нэрийн өмнөөс захиалга оруулах, худалдах, худалдан авах гэрээ байгуулах эрхийг ойлгох бөгөөд байнгын гишүүн нь Биржтэй байгуулсан гишүүнчлэлийн гэрээний хүчинтэй хугацаанд арилжааны эрх эдэлнэ.
- 3.12 Арилжааны эрхтэй байнгын гишүүн дараах үйл ажиллагааг эрхэлнэ. Үүнд:
- 3.12.1 Харилцагчтай зуучлалын гэрээ байгуулна.
  - 3.12.2 Харилцагчийн захиалгын дагуу арилжаанд авах болон зарах захиалга оруулна.
  - 3.12.3 Харилцагчийн хэлцлийн жагсаалтыг захиалгатай тулгаж, худалдах, худалдан авах гэрээг харилцагчийн олгосон итгэмжлэлийн хүрээнд байгуулж болно.
  - 3.12.4 Холбогдох хууль, журмын дагуу худалдах, худалдан авах гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллана.

**3.13 Клирингийн эрх:** Харилцагчийн нэрийн өмнөөс дэнчин, барьцаа байршуулах, худалдах, худалдан авах гэрээний төлбөр тооцоо гүйцэтгэх эрхийг ойлгох бөгөөд клирингийн эрхтэй байнгын гишүүн дараах үйл ажиллагааг эрхэлнэ. Үүнд:

3.13.1 Харилцагчийн барьцаа хөрөнгө байршуулна.

3.13.2 Худалдах, худалдан авах гэрээний төлбөр, тооцооны хэрэгжилтийг хангаж ажиллана.

3.13.3 Харилцагчийн хэлцэлд харгалзах худалдах, худалдан авах гэрээний төлбөрийг Биржээс баталсан бараа хүлээлцэх баримтыг үндэслэн гүйцэтгэнэ.

3.13.4 Харилцагчийн хэлцэлд харгалзах худалдах, худалдан авах гэрээний төлбөрийг гүйцэтгэхдээ арилжаа, төлбөр тооцоотой холбоотой аливаа шимтгэл хураамж, бусад хүү төлбөрийг суутгаж болно.

**3.14 Зах зээл үүсгэх эрх:** Биржийн арилжаанд зах зээл үүсгэх захиалга оруулах эрхийг ойлгох бөгөөд зах зээл үүсгэх эрхтэй байнгын гишүүн өөрийн нэрийн өмнөөс бараа, түүхий эдэд суурилсан гэрээний авах болон зарах захиалгыг зэрэг оруулах боломжтой. Зах зээл үүсгэх захиалгыг Биржээс тогтоосон нөхцөлийн дагуу оруулна.

Биржийн байнгын гишүүний шалгуур үзүүлэлт

3.15 Барааны брокер буюу агуулах дахь барааны чанар, стандарт хариуцагч брокер, захиалгын брокер, биржтэй харилцах, дотоод хяналтыг хэрэгжүүлэх ажилтантай байна.

3.16 Байнгын гишүүн нь Биржийн системд харилцагчийн бүртгэл үүсгэх, харилцагчийн захиалга хүлээн авах, захиалгын дагуу арилжаанд орох, захиалга биелүүлэх, цуцлах, дуусгавар болгох, төлбөр тооцоо гүйцэтгэх ажлыг гүйцэтгэнэ.

3.17 Байнгын гишүүн нь Санхүүгийн зохицуулах хороо болон Биржийн холбогдох журамд заасны дагуу тайлан гаргаж хүргүүлэх ба Гишүүнчлэлийн гэрээг сунгахад гэрээ дүгнэсэн акт үйлдэнэ.

Биржийн байнгын бус гишүүний үйл ажиллагаа:

3.18 Байнгын бус гишүүн нь арилжааны програмд зарах захиалга оруулах, анхан шатны тордолт хийж стандартын шаардлага хангасан бараа, түүхий эдийг биет байдлаар нийлүүлэх, хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл эрхлэгчдээс бүрдсэн хоршоо байна.

3.19 Байнгын бус гишүүн нь Биржтэй Гишүүнчлэлийн гэрээ байгуулснаар өөрийн нэрийн өмнөөс арилжаанд зөвхөн зарах захиалга оруулна.

3.20 Байнгын бус гишүүн нь энэхүү журмын 3.18-д зааснаас гадна байнгын гишүүнтэй Зуучлалын гэрээ байгуулж, биржийн арилжаанд оролцож болно.

3.21 Байнгын бус гишүүн нь өөрийн бараа, түүхий эдийн чанар, захиалгын үнэн бодит байдлыг хариуцах бөгөөд захиалгат түүхий эд нь чанарын шаардлага хангаагүйгээс үүсэх хохирлыг барагдуулна.

3.22 Байнгын бус гишүүн нь дараах шалгуур үзүүлэлтийг хангасан байна. Үүнд:

3.22.1 Хуульд заасны дагуу үүсгэн байгуулагдсан, үйл ажиллагаагаа явуулж буй хоршоо байх;

3.22.2 Үйл ажиллагаа явуулж буй тухайн сумын малчин өрхийн 25-аас доошгүй хувьд үйлчилгээ үзүүлэх боломжтой байх;

3.22.3 Газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч, тухайн болон харъяа сумын иргэд, аж ахуйн нэгжид үйлчилгээ үзүүлэх чадамжтай байх;

3.22.4 Гишүүдэд биржийн арилжааны зах зээлийн талаар мэдээлэл өгөх, тухайн хоршоог төлөөлж бирж болон биржийн байнгын гишүүнтэй харилцах, биржийн арилжаанд оролцох, дотоод хяналтыг хэрэгжүүлэх ажилтантай байх;

3.22.5 Гишүүдийн захиалгад харгалзах бараа, түүхий эдийг биржийн барааны тодорхойлолтод заасны дагуу чанар, стандартыг хариуцах ажилтантай байх;

3.22.6 Интернэтэд холбогдох боломжтой компьютер, гар утас болон бусад тоног төхөөрөмжтэй байх;

3.22.7 Биржээр арилжих бараа, түүхий эдийг хадгалах, анхан шатны тордолт, чанарын хамгаалалт хийх боломжтой өөрийн эсвэл гэрээт итгэмжлэгдсэн агуулахтай байх;

3.22.8 Хүнсний улаанбуудай, тосны ургамал /рапс/ арилжих, биржийн итгэмжлэгдсэн агуулахтай хамтран ажиллах гэрээ байгуулсан байх;

3.23 Биржийн байнгын бус гишүүн нь жилд нэг удаа тайлан гаргаж Биржид хүргүүлэх ба Гишүүнчлэлийн гэрээг сунгахад гэрээ дүгнэсэн акт үйлдэнэ.

#### **Дөрөв. Гишүүнээр элсэх**

4.1 Энэхүү журмын 3.7-т заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээд нь Биржийн байнгын гишүүнээр, хоршоо нь Биржийн байнгын бус гишүүнээр элсэх хүсэлт гаргана.

4.2 Биржийн гишүүнээр элсэх хүсэлтэд хавсаргах баримт бичгийн бүрдэлийг энэхүү журмын хавсралтаар батална. /Хавсралт 1/

4.3 Гишүүнээр элсэхийг хүсч буй этгээд нь түүний өргөдлийг хүлээн авч шийдвэрлэх хүртэл хугацаанд биржээс тодруулсан эсвэл нэмж шаардсан мэдээлэл, бичиг баримтыг тухай бүрт гаргаж өгнө.

4.4 Бирж нь хүсэлт гаргагч этгээдийн шалгуур үзүүлэлтийг хангаж буй байдал, баримт бичгийн бүрдэл, агуулга болон гишүүнчлэл хариуцсан хэлтсийн санал дүгнэлтийг харгалзан баримт бичиг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 өдрийн дотор дараах шийдвэрийг гаргана. Үүнд:

4.4.1 Гишүүнээр элсүүлэх тухай шийдвэр гаргаж, Гишүүнчлэлийн гэрээ байгуулах;

4.4.2 Гишүүнээр элсэхээр хүсэлт гаргагчийн баримт бичиг нь шаардлага хангаагүй гэж үзвэл нэмэлт баримт бичгийг ажлын 3 өдрийн дотор бүрдүүлэхийг шаардах, буцаах;

4.4.3 Биржийн гишүүнээр элсүүлэхээс татгалзах.

4.5 Дараах тохиолдолд хүсэлт гаргагчийн баримт бичгийг буцаана. Үүнд:

4.5.1 Баримт бичгийн бүрдэл дутуу, хуурамч, хүчин төгөлдөр бус, буруу мэдээлэл агуулсан;

4.5.2 Хүсэлт гаргагч баримт бичгийг буцаах хүсэлт гаргасан.

4.6 Биржийн гишүүнээр элсүүлэхээс татгалзах шийдвэр гаргасан бол холбогдох шийдвэрийг үндэслэл бүхий тайлбарын хамт хүсэлт гаргагч этгээдэд бичгээр хүргүүлнэ.

#### **Тав. Гишүүнчлэлийн гэрээг дуусгавар болгох**

5.1 Гишүүнчлэлийн гэрээг дараах тохиолдолд дуусгавар болсонд тооцно. Үүнд:

5.1.1 Гэрээний хугацаа дуусгавар болсон;

5.1.2 Энэхүү журмын 3.4-т заасны дагуу гэрээг сунгах хүсэлт ирүүлээгүй;

5.1.3 Гэрээг хугацаанаас өмнө дуусгавар болгох тухай Гүйцэтгэх захирлын шийдвэр гарсан;

5.1.4 Гишүүн өөрөө хүсэлт гаргасан;

5.1.5 Гэрээнд заасан бусад.

5.2 Гишүүнчлэлийн гэрээ дуусгавар болсон тухай мэдээллийг гэрээ дуусгавар болсон өдөрт багтаан Биржийн цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээллэнэ.

### **Зургаа. Хяналт, шалгалт, хүлээлгэх хариуцлага**

6.1 Бирж нь гишүүний үйл ажиллагаа холбогдох хууль, журам, шийдвэрийн хүрээнд явагдаж байгаа эсэхэд хяналт тавьж ажиллана.

6.2 Энэ журам болон Гишүүнчлэлийн гэрээнд заасан биржийн гишүүнд тавигдах шалгуур үзүүлэлт, эрх үүргийн хэрэгжилт хангагдаж байгаа эсэхийг Хяналтын журамд заасны дагуу шалгалт зохион байгуулж хянана.

6.3 Биржийн гишүүн нь холбогдох хууль, журам, шалгуур үзүүлэлт, Гишүүнчлэлийн гэрээг зөрчсөн тохиолдолд зөрчлийн шинж байдал, компанид учруулсан хохирлын хэмжээ, хяналт, шалгалтын тайлан дүгнэлт зэргийг харгалзан Гүйцэтгэх захирал дараах арга хэмжээг авна. Үүнд:

6.3.1 Сануулах;

6.3.2 Гишүүний эрхийг бүхэлд нь болон хэсэгчлэн түдгэлзүүлэх;

6.3.3 Гишүүний эрхийг цуцлах.

6.4 Биржийн гишүүн нь энэхүү журам болон бусад холбогдох дүрэм журмын заалтыг мэдэхгүй, эсвэл ойлгоогүй байх нь тухайн этгээдийг эдгээр заалтыг биелүүлэх, дагаж мөрдөхөөс чөлөөлөх үндэслэл болохгүй.

## Байнгын гишүүний бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт

| №  | Бүрдүүлэх баримт бичиг  | Шинээр элсэх | Гэрээ сунгах |
|----|---|--------------|--------------|
| 1  | Байнгын гишүүнээр элсэх, гэрээ сунгах өргөдөл   | ✓            | ✓            |
| 2  | Биржийн гишүүний анкет /эх хувьтай тулгах/  | ✓            |              |
| 3  | Хуулийн этгээдийн Улсын бүртгэлийн гэрчилгээ*/эх хувьтай тулгах/  | ✓            |              |
| 4  | Улсын бүртгэлийн ерөнхий газраас авсан, компанийн хувьцаа эзэмшигчдийн лавлагаа, охин компанид хөрөнгө оруулалт хийсэн толгой компанийн лавлагаа; | ✓            |              |
| 5  | Агуулахын эзэмшигчийг нотлох бичиг баримт эсвэл итгэмжлэгдсэн агуулахтай хамтран ажиллах гэрээ /эх хувьтай тулгах/                                | ✓            | ✓            |
| 6  | Санхүүгийн зохицуулах хорооны тусгай зөвшөөрөл  | ✓            | ✓            |
| 7  | Эрх бүхий албан тушаалтан, ажилтнуудын анкет, нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар   | ✓            |              |
| 8  | Брокерын эрх авсан ажилтнуудын үнэмлэх  | ✓            |              |
| 9  | Ажилтантай байгуулсан нууцлалын гэрээ /эрх бүхий ажилтны гарын үсэг бүхий албан бичиг/  | ✓            | ✓            |
| 10 | Байнгын гишүүний үйл ажиллагаа явуулах байрны үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ эсвэл түрээсийн гэрээ   | ✓            |              |
| 11 | Сүүлийн нэг жилийн аудитлагдсан санхүүгийн тайлан, үйл ажиллагаа эхэлж байгаа бол эхлэлтийн тайлан, Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулга        | ✓            |              |
| 12 | Санхүүгийн бичиг баримт дээр гарын үсэг зурах эрх бүхий этгээдийн гарын үсгийн нотариатаар баталгаажсан хувь                                      | ✓            | ✓            |

## Байнгын бус гишүүний бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт

| № | Бүрдүүлэх баримт бичиг  | Шинээр элсэх | Гэрээ сунгах |
|---|---|--------------|--------------|
| 1 | Байнгын бус гишүүнээр элсэх өргөдөл, гэрээ сунгах өргөдөл   | ✓            | ✓            |
| 2 | Эрх бүхий албан тушаалтан болон ажилтнуудын анкет   | ✓            | ✓            |
| 3 | Хоршооны улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар  | ✓            |              |
| 4 | Хоршооны дүрмийн хуулбар  | ✓            |              |
| 5 | Хоршооны үйл ажиллагааны төлөвлөгөө   | ✓            |              |
| 6 | Хоршооны ажилтан болохыг нотлох хоршооны даргын тодорхойлолт  | ✓            | ✓            |
| 7 | Санхүүгийн бичиг баримтад тухайн хоршоог төлөөлөх этгээдийн гарын үсгийн баталгаа                             | ✓            | ✓            |
| 8 | Үйл ажиллагаа явуулж буй сумын малчин өрхөд үйлчилгээ үзүүлэхээр байгуулсан гэрээний хуулбар, жагсаалтын хамт | ✓            |              |
| 9 | Агуулахын талаарх мэдээлэл, гэрээний хуулбар;   | ✓            | ✓            |